



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/278

Булган сум

Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газрын  
барилга хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалт, мөн газрын 2024 оны 671, 2025 оны 166 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газрын барилга 934,390,246 (есөн зуун гучин дөрвөн сая гурван зуун ерэн мянга хоёр зуун дөчин зургаа) төгрөгийн хөрөнгийн барилгыг, бүртгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: А.Сарантуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)  
Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)  
Б.Бямбажав (Баян-Агт сумын Засаг дарга)  
Ж.Эрдэнэбулган (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)  
Г.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)  
Нарийн бичгийн дарга Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт холбогдох бичиг баримтыг баталгаажуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн

баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд"-д бүртгэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР